Засгийн газрын 2024 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр											
Д/д	Зорилго	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжилт 2025 оны эхний хагас жил	Гүйцэтгэлийн хувь	Хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар бичих	Гүйцэтгэлийн хувь	Батлагдсан төсөв	Батлагдсан эх үүсвэр	Санхүүжилтийн гүйцэтгэл	Санхүүжилтийн эх үүсвэр
НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО											
1.1. Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт											
2.2. Эрдэм боловсролтой монгол хүн											
2.3. Эрүүл Монгол хүн											
36	2.3.1. Нийгмийн эрүүл мэнд	2.3.1.1. Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	387. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлж, идэвхжүүлэх	Хүн амд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг дэмжихээр Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нийт 160 орчим сая төгрөгийн санхүүжилтийг шийдүүлсэн. Хагас жилийн байдлаар сүрьеэ, БЗДХалдварын болон хавдрын эрт илрүүлгийг нийт 3 бүсийн 10 гаруй суманд зохион байгуулж нийт 410 иргэдийг үзлэг, оношилгоонд хамруулан 107 өвчлөлийг илрүүлэн ажилласан.	90%	Эрүүл мэндийн салбарт ОНХОруулалтаар 5 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилтэд нийт 105,753,700 төгрөгийн шийдвэрлэж дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Үүнд: 1. “Эх хүүхдийн эрүүл мэнд, эрт илрүүлэг”-ийн хөтөлбөр арга хэмжээнд 24,848,000 төгрөг 2. Хэрлэн сумын засаг даргаас Хэрлэн сумын иргэдийн сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгийн зардалд 2,000,000 төгрөг 3. "Хавдрын эсрэг хамтдаа" арга хэмжээ эрт илрүүлэг оношлуур, тоног төхөөрөмж, сургалтын үйл ажиллагааны зардалд 48,080,700төгрөг 4. "Эрүүл эхээс-Эрүүл нярай" Эх хүүхдийн эрүүл мэндийн дэмжих сургалт үйл ажиллагааны зардалд 25,125,000 төгрөгөөр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсэн.	100%				
37		2.3.1.2. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйлс, архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратегийн тусламжтайгаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжинэ.	394. "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах" арга хэмжээ хэрэгжүүлэх	АНЭ, Өрх, сумын ЭМТөвүүдээр үйлчлүүлсэн иргэдийн дунд халдварт өвчний хам шинжийн тандалтыг тогтмол хийн Халдварт өвчин судлал үндэсний төвийн Эрт сэрэмжлүүлэг хариу арга хэмжээний албанд мэдээлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудыг халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдлын эргэн мэдээллээр хангаж, холбогдох мэргэжилтнүүд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мөн ЭМЯ-аас өгсөн чиглэлийн дагуу Дархлаажуулалтын 10 хоногийг орон нутагтаа зохион байгуулж Улаанбурхан өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэн улаанбурхан, гахайн хавдар, улаанууд өвчний эсрэг вакцин буюу УГУ1, УГУ2 дугаар тунд хамрагдаагүй 9 сартай болон 2 настай 640 хүүхдийг нөхөн дархлаажуулалтад хамруулсан. ХӨСҮТ-ийн лавлагаа лабораторид Улаанбурханы сэжигтэй тохиолдлын 70 сорьц хүргүүлснээс 41 батлагдсан, Хавьтлын тоо 699, Голомтын дархлаажуулалтад 268 иргэдийг хамруулсан. ЭМБ-ууд улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга зам, дархлаажуулалтын талаар цахим хуудсандаа байршуулан олон нийтэд түгээж эцэг, эх асран хамгаалагч нарт заавал хийх товлолын дархлаажуулалтыг сурталчлан таниулан ажиллаж байна.	90%	Хэнтий аймгийн хэмжээнд эхний 10 сарын байдлаар “Осол гэмтлээс сэргийлэх 0-5 насны хүүхдийн аюулгүй орчин” сарын аян, “Хорт хавдрын эсрэг анхаарал хандуулах сарын аян”, “Дэлхийн тамхигүй өдөр” аян, Тамхигүй ирэздүй сарын аян, Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, нөхөн дархлаажуулалтын ач холбогдол зэрэг арга хэмжээний хүрээнд 13 сэдвээр Эрүүл мэндийн газраас иргэдэд 63, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас иргэдэд 201 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулан, зорилтот бүлгийн 36% буюу насанд хүрсэн 5065 иргэд олон нийт, өсвөр насны 4020 хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсролыг хүргэн ажилласан. Мөн цахим хуудсаар дамжуулан дунджаар 17360 иргэд олон нийтэд мэдээ мэдээлэл хүргэсэн. "Идэвхтэй хөдөлгөөн Эрүүл Хэнтийчүүд" аяны хүрээнд "Эрүүл зөв хооллолт, идэвхтэй хөдөлгөөн" сэдвээр аймгийн төвийн байгууллага, аж ахуйн нэгжид 22 удаагийн сургалтыг зохион байгуулж 1597 алба хаагчид, дасгал хөдөлгөөнд 80 гаруй байгууллагын 21580 иргэн хамрагдсан.	100				
38	2.3.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж	2.3.2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна. /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний төв/.	401. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх	Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах, нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор ЭМСайдын тушаалаар томилогдсон "Хавдар судлал", "Ангиографи"-ийн үндэсний багтай хамтран ажиллаж байна. Ингэснээр төрөлжсөн нарийн мэргэшлийн тусламж, үйлчилгээг орон нутагтаа цаг алдалгүй авах, төвлөрлийг сааруулах боломжийг бүрдүүлэх юм. Хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор нэгдсэн эмнэлэгт хавдрын хими болон хөнгөвчлөх эмчилгээг хийхээр төлөвлөн шаардлагатай тоног төхөөрөмж болон хүний нөөцийн бэлэн байдлын ханган ажиллаж байна.	70%	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна. /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-II, Халдварт өвчин судлалын үндэсний төв-II, Зүрх судасны үндэсний төв/. Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах зорилготой Эрүүл мэндийн сайдын тушаалаар томилогдсон Үндэсний багийн 8 гишүүн 2025 онд нэг удаа ирж ажилласан. Энэ хугацаанд ангиографын оношилгоог 22 иргэнд, зүрхний үзлэгийг 61, хавдрын үзлэг, оношилгоог 80 иргэнд хийж зөвлөгөө өгсөн. Мөн нэгдсэн эмнэлгийн холбогдох эмч, мэргэжилтнүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажлын байрны дадлага, сургалтыг хийж ажилласан. Ангиографын оношилгоо, эмчилгээг нутагшуулах зорилгоор УХТЭ-ийн эмч нартай хамтран ажиллаж байна. Мөн орон нутагтаа хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хими эмчилгээг нутагшуулах зорилгоор ХСҮТ-тэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний хэрэгжилтийн хүрээнд хавдрын хими эмчилгээний эмч, сувилагч, эмч зүйч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулан эмчилгээг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. .	100				
Үнэлгээний дундаж											